Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 01 дүгээр сарын 03 өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан М.Хосбаяр 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл, Н.Шагдарсүрэн 2021.12.23-ны өдрөөс эхлэн, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баярмаа нар зурж байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь: Бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэмжүүр хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, шалгалт тохируулга, стандарт түгээлт, сургалт сурталчилгаа, үнэт металлд сорьц тогтоох үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй.

Тус байгууллага нь аймаг орон нутгийн хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилго зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд улсын хэмжээнд Дархан-уул, Баянхонгор аймагт алтны сорьцын лаборатори ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан салбарын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний дотоод хяналт, шалгалтын хэлтэс ажилладаг бөгөөд Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 409,942.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,149.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,611.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 4,611.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80,700.7 мянган төгрөгөөр буюу 39.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс байна.

1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Аудитын код БНА-2022/104/НА-СТА-ТШЗ



**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	32,174.4	114,525.1	82,350.7
Мөнгөн хөрөнгө	-	1,018.9	1,018.9
Авлага	14,641.2	82,185.0	67,543.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	17,533.2	31,321.2	13,788.0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	171,366.5	170,735.2	(631.3)
Үндсэн хөрөнгө	212,664.3	219,345.6	6,681.3
Хуримтлагдсан элэгдэл	(41,297.8)	(48,610.4)	(7,312.6)
<b>Нийт хөрөнгө</b>	203,540.9	285,260.2	81,719.4
Өр төлбөр	-	478.5	478.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	203,540.9	284,781.7	81,240.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	203,540.9	285,260.2	81,719.4

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,018.9 мянган төгрөг нь ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн зарцуулагдаагүй үлдэгдэл болно.

Тайлант оны дансны авлагын үлдэгдэл 82,185.0 мянган төгрөг болж өмнөх оноос 67,543.8 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааны давсан орлогыг буцаан төвлөрүүлснээс үүссэн авлага 48950,7 мянга, хөрөнгө бэлтгэх, ажил гүйцэтгэхээр мөнгийг шилжүүлж хөрөнгийг аваагүйгээс 28,297.0 мянган төгрөгийн алдааг залруулсантай холбоотой байна

**Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн авлагын тодруулга**

/ мян. төг/

№	Бэлтгэн нийлүүлэгчийн нэр	Нийлүүлэх хөрөнгийн нэр	Гэрээ байгуулсан огноо дуусах хугацаа	Гэрээний дүн	Авлагын дүн
1	Баянхонгор аймгийн Мэдээлэл технологийн төв	Notebook 6ш	2021.12.23-2022.03.сар	13,800.00	9,200.00
2	"Си Эл энд Эс Эм" ХХК	Лабораторын агааржуулалт	2021.12.23-2022.03.сар	8,000.00	8,000.00
3	БИ АЙ ЭМ БИ ХХК	Тавилга, аж ахуйн эд хогшил	2021.12.23-2022.03.сар	1,580.00	480.00
4	МЭЙЖҮРМЭНТ	Тоног төхөөрөмж	2021.12.22-2022.03.сар	10,617.00	10,617.00
5	Сангийн яам	Давсан орлогын авлага			48,950.7
6	БИ ЭЙЧ ЭНД ДИ ХХК	Грашийн барилга барих	2020.12.22	4,602.0	4,602.0
7	Ажилчдаас авах авлага	НДШ, ХХОАТ	2021.12.23	335.3	335.3
Авлагын дүн				33,997.00	82,185.0

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн авлагын тодруулга тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 31,321.2 мянган төгрөг болж 13,788.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 35,986.3 мянга, Стандарт, хэмжил зүйн газраас үнэ төлбөргүй олгосон 613.0 мянга нийт 36,599.3 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой бөгөөд лабораторийн алт хайлуулах урвалж бодис 25,967.7 мянган төгрөгөөр худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 219,345.6 мянган төгрөг болж 6,681.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,681.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн зарлага гараагүй байна.

Ажиллагсадтай холбоотой өглөгийн данс 478.5 мянган төгрөгөөр өссөн нь 2021 оны 12 дугаар сард ажилчдад олгосон үр дүнгийн урамшууллаас НДШ болон ХХОАТ суутган тооцоогүй, нийт цалингийн дүнд оруулж аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын хэлтэст мэдээлсэнтэй холбоотойгоор үүссэн өрийг санхүүгийн тайланд залруулж бүртгэсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 284,781.7 мянган төгрөг болж 81,240.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 81,240.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 365,490.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 365,490.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 109,059.9 мянган төгрөгөөр бууруулж 256,413.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсөвт 2 удаа өөрчлөлт оруулан тодотголоор 251,755.5 мянган төгрөг болгож 4,675.5 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 251,755.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 130,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 121,755.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 121,755.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 117,222.6 мянган төгрөгийг зарцуулж 4,532.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 247,222.6 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь эд хогшил худалдан авах зардал 1,480.0 мянга, дотоод албан томилолтын зардал 2,792.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 260.5 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Нэмэлт санхүүжилтийн дансаар давсан орлогоос нийт 114,340.3 мянган төгрөгийн орлого зарлагын гүйлгээг хийсэн байгааг дэлгэрэнгүй харуулав.

*Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн дансны зарлагын голлох нөлөө үзүүлж байгаа дүн /төг/*

№	Огноо	Байгууллагын нэр	Гүйлгээний утга	Орлого	Зарлага
1	2021.12.24	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Орлого	114,340.3	-
2	2021.12.22	Хурц гал ххк	лабораторийн урвалж бодис, хайлтын тогоо авахад	-	4,335.5
4	2021.12.24	МЭЙЖҮРМЭНТ	Тоног төхөөрөмж	-	10,617.00
5	2021.12.24	"Си Эл энд Эс Эм" ХХК	Агааржуулалтын хоолойн засвар	-	8,700.00
6	2021.12.24	БИ АЙ ЭМ БИ ххк	Тавилга	-	1,580.00
7	2021.12.24	Ажиллагсдад тэтгэмж	ХЧТА-н даатгал	-	2,757.00
8	2021.12.24	Д.Баярмаа /нягтлан бодогч/	Нэг удаагийн буцалтгүй тусламж	-	7,500.00
9	2021.12.24	"Айе Ти Юнипикешн" ХХК	Компьютерын үнэ	-	13,800.00
10	2021.12.24	Сангийн яам	Буцаан төвлөрүүлэлт	-	48,950.7
11	2021.12.24	Стандарт хэмжил зүйн хэлтэс	Бусад зардал	-	16,100.1

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны мөнгөн хөрөнгийн журналаас*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Н.Бунчинсүрэн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 5 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 80 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Стандарт хэмжил зүйн газраас тус байгууллагын 2021 оны өөрийн орлогыг 130,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж баталсан ба гүйцэтгэлээр 274,212.6 мянган төгрөгийг оруулж 144,212.6 мянган төгрөгөөр давж биелүүлсэн.

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021.10.15-ны өдрийн 01/604 дугаартай албан бичгээр үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг 2021.10.29-ны дотор төвлөрүүлэхийг мэдэгдсэн байхад төвлөрүүлээгүй атлаа байгууллагын даргын 2021.11.01-ны өдрийн 107 дугаартай албан бичгээр давсан орлогыг зарцуулах эрх олгох хүсэлтийг Стандарт хэмжил зүйн газарт явуулсан..

Сангийн сайдын 2021.12.10-ны өдрийн 217 дугаартай тушаалаар 101,978.6 мянган төгрөгийн давсан орлогыг зарцуулах эрхийг олгох шийдвэр гаргуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 317,696.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 92,246.8 мянган төгрөгөөр буюу 22.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал тус тус нэмэгдсэн, хангамж, бараа материалын зардал, нормативд зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 450,938.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 479,463.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулж 30,844.8 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	146	3	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

#### 3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

Тус байгууллагын 2021 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,611.5 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд тайлант онд 2 удаа 1,139.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон ба 16,471.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,700.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 60.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг 2021.06.18-ны өдрийн 74 дугаартай албан бичгээр ирүүлсэн боловч зөвлөмжөөр өгсөн гүйцэтгэгч компаниар 4,602.0 мянган төгрөгийн грашийн барилгыг бариагүй байхад нягтлан бодогч авлагыг хааж, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн нь зөвлөмж хэрэгжүүлээгүй гэж үзэв.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2021.10.15-ны өдрийн 01/604 дугаартай албан бичгээр үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг 2021.10.29-ны дотор төвлөрүүлэхийг мэдэгдсний дагуу төвлөрүүлээгүй зөрчил гаргасан байхад атлаа байгууллагын даргын 2021.11.01-ны өдрийн 107 дугаартай албан бичгээр давсан орлогыг зарцуулах эрх олгох хүсэлтийг Стандарт хэмжил зүйн газар хүлээн авч Шадар сайдад уламжилж давсан орлогыг зарцуулах эрхийг Сангийн яамнаас гаргуулсан байна.

Иймд төсвийн дотоод хяналтыг шат бүртэй хэрэгжүүлж хяналт тавиагүйгээс дээр зөрчил гарч байгаа тул Стандарт хэмжил зүйн газрын Төвлөрүүлэн захирагчийн аудитын тайланд авч үзэж Төсвийн тухай хуулийн шат бүртэй хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг өгүүлэх саналтай байна.

**Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 123,469.7 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 28,297.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 5,058.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, дээд байгууллагаас ирүүлсэн чиглэлийг мөрдөн ажиллах 90,114.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

**4.1 Залруулсан алдаа**

1."Си Эл энд Эс Эм" ХХК-тай лабораторийн агааржуулалтын системийн ажлыг гүйцэтгэх 8,000.0 мянга, МЭЙЖҮРМЭНТ ХХК-тай 2021.12.21-ны өдөр байгуулсан гэрээний дагуу тоног төхөөрөмжийн үнэнд 10,617.0 мянга, Баянхонгор аймгийн Мэдээлэл технологийн төвтэй 2021.12.23-ны өдөр 6 компьютер худалдан авахаар гэрээ байгуулсан 9,200.0 мянга, "БИ АЙ ЭМ БИ" ХХК-д шилжүүлсэн ширээний үнэ 480.0 мянга, нийт 28,297.0 мянган төгрөгийн хөрөнгийг ирээгүй байхад орлого авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлангийн "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд дансны авлагаар 28,297.0 мянган төгрөгийг тусгуулж тайланг залруулав.

**4.2 Төлбөрийн акт**

1.Тус байгууллагын даргын 2021.12.14-ны өдрийн А/22 дугаартай тушаалаар ажилчдад 1,647.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо ажилчдаас НДШ-ийн 189.5 мянга, ХХОАТ-ын 145.8 мянга нийт 335.3 мянган төгрөгийг суутган тооцоогүй олгосон байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх"; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтыг

**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоогүй НДШ, ХХОАТ-ын 335.3 мянган төгрөгийг холбогдох ажилчдаас төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, гүйцэтгэгч “БИ ЭЙЧ ЭНД ДИ” ХХК-иар 4,602.0 мянган төгрөгийн грашийн барилгыг бариагүй байхад нягтлан бодогч авлагыг хааж, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21.2.“Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, БИ ЭЙЧ ЭНД ДИ ХХК-тай 2020 онд байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ны заалт, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Грашийн барилгын төлбөр 4,602.0 мянган төгрөгийг “БИ ЭЙЧ ЭНД ДИ” ХХК-иар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3.Ажилтнуудын 2021 оны 7-р сарын цалингаас НДШ-ийг бүрэн суутгасан атлаа НДХ-т мэдээлэхдээ техникч Батбаатарын цалинг 72.0 мянга, химич Цэдэвсүрэнгийн цалинг 430.9 мянга нийт 502.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлснийг санхүүгийн тайланд 120.7 мянган төгрөгийн өглөгөөр бүртгэж, НДХ-т мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 120.7 мянган төгрөгийг НДШ-ийн өглөгөөр тусгуулж, дээрх 2 ажилчдын цалинг нөхөн мэдээлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

#### **4.3 Аудитын зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал**

1.Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021.10.15-ны өдрийн 01/604 дугаартай албан бичгээр үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг Стандарт, хэмжил зүйн газрын 100900009012 тоот дансанд 2021.10.29-ны дотор төвлөрүүлэх үүрэг өгсөн байхад 90,114.7 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дугаартай тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.4 дэх заалтыг зөрчсөн байна.

##### **Өгсөн зөвлөмж**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өгсөн чиглэлийн дагуу давсан орлогыг холбогдох журмын дагуу төвлөрүүлж, нягтлан бодогчтой холбоотой дотоод хяналтыг сайжруулах.

2. Шилэн дансны цахим сайтад нийт 151 мэдээлэл оруулахаас 149 мэдээлэл оруулсан бөгөөд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 30,844.8 төгрөгийн тэтгэмжийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага,

Аудитын код БНА-2022/104/НА-СТА-ТШЗ



**Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 3 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

3.Тус байгууллагын 2021 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,611.5 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 2021 онд 1,139.8 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон ба 16,471.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй хэмнэлт 1,139.8 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоол, СХЗГ-өөс ирүүлсэн чиглэлийг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс	9	33,355.0	4	28,297.0	3	5,058.0	0	0	3	90,114.7

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_